

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧ ЯВГАН ЗОРЧИГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Г.Бат-Эрдэнэ
*Цагдаа судлалын магистрант,
цагдаагийн ахлах дэслэгч*

Товчлол. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай шинэ хууль 2015 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэхүү хуульд анх удаа явган зорчигчид ногдох хариуцлагын механизмыг оруулсан. Өөрөөр хэлбэл өмнө нь жолооч явган зорчигчид зам тавьж өгөх үүрэгтэй байсан бол шинэ хуульд замын хөдөлгөөнд хууль зорчиж оролцсон явган зорчигчид хариуцлага хүлээлгэх талаар зааж өгсөн нь явган зорчигчийн эрх зүйн байдалд нэлээн томоохон өөрчлөлт орох үндэслэл болж байна.

Энэхүү өгүүлэлд замын хөдөлгөөнд оролцогч явган зорчигчийн зам тээврийн осол, зөрчилд хэрхэн өртөж байгаа болон явган зорчигчийн эрх зүйн байдал Монгол Улсын хууль тогтоомжид хэрхэн тусгагдсан талаар товч авч үзсэн болно.

Түлхүүр үг. Замын хөдөлгөөн, явган зорчигч, зам тээврийн осол, зөрчил, тээврийн хэрэгсэл, автомашин

Удиртгал. Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д “замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах гэдэг нь зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, ослоос үүдэн гарах хохирлыг багасгахад чиглэсэн үйл ажиллагааг”, 8 дугаар зүйлийн 8.1-т “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүргийг ... замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт тавих, замын хөдөлгөөнд оролцогчийн хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг хангах зорилгоор замын хөдөлгөөнийг зохицуулах”¹ гэж заасан байдаг. Эдгээр заалтууд нь иргэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчил, ослоос ангид байж эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хамгаалуулах эрх зүйн үндэс болж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль нь замын хөдөлгөөний зохион байгуулалт, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, осол, хэрэг, зөрчлийг бууруулах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эрх ашгийг хамгаалахад чиглэсэн үзэл баримтлалаар 2015 онд шинэчлэн батлагдсан юм. Энэхүү хуулиар явган зорчигч²ийн эрх зүйн байдлыг тодорхой хэмжээгээр тусгасан байдаг боловч зарим харилцааг журам, дүрмээр зохицуулж байгаа нь өнөөдрийн тулгамдсан асуудал гэж судлаачийн хувьд харж байна.

Үндсэн хэсэг. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь нийгмийн хөгжлийн зүй тогтлын дагуу олон хүчин зүйл болох эдийн засаг, улс төр, эрх зүй, соёл, хүн ам зүй, техник, технологийн хөгжлөөс хамааран хувьсан өөрчлөгдөж байна. Өнөөгийн нийгэмд хамгийн их эрсдэл учруулж байгаа зүйл бол авто машины осол, аваар бөгөөд зөрчил гарахад согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох, хурд хэтрүүлэх, хамгаалалтын бүс, малгай хэрэглэхгүй байх, гар утсаар ярих, нүүрээ будах /эмэгтэйчүүд/, тамхи асаах, хүүхэдтэйгээ зууралдах зэргээр анхаарал сарнихад жолоочийн хөдөлгөөн удаашрах, гэрэл дохио анхаарахгүй, эгнээ байр эзлэхдээ

¹ Төрийн мэдээлэл. 2015. №28. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль

² "явган зорчигч" гэж замаар явган яваа /зам дээр ажил үүрэг гүйцэтгэж яваагаас бусад/ хүн, жагсаалаар яваа болон хөгжлийн бэрхшээлтэй хүний тэргэнцэртэй, түүнчлэн тэрэг түрж, чарга чирж, мотоцикл, мопед, унадаг дугуйг хөтөлж замаар яваа хүнийг ойлгоно. /Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3.1.11/

бусдыг анзаарахгүй байх, хажуу хоорондын зайг тохируулахгүй байх нь жолоочийн ур чадварт шууд нөлөөлдөгөөс гадна явган зорчигчийн аюулгүй байдалд шууд нөлөөлөх нэг хүчин зүйл болж байна.

Зөвхөн 2021 онд зам тээврийн ослын улмаас 383 хүн нас барсны 129 буюу 33.6% явган зорчигч байгаагаас Нийслэлд 72 буюу 55.8%, орон нутагт 57 буюу 44.2% эзэлж байна. Мөн ослын улмаас гэмтсэн 2475 хүний 1095 буюу 44.2% явган зорчигчоос Нийслэлд 875 буюу 79.1%, орон нутагт 220 буюу 20.1% эзэлж байна. Энэ нь зам тээврийн ослын улмаас нас барсан 3 хүн тутмын 1, гэмтсэн 5 хүн тутмын 1 нь явган зорчигч байгааг харуулж байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд явган зорчигч мөргүүлэх хэлбэрийн зам тээврийн ослын улмаас 709 хүн нас барж, 9134 хүн гэмтсэн байна. Нас барсан хүний 55.8% нийслэлд, 44.2% орон нутагт бүртгэгдсэн байна. Гэмтсэн хүний 86.9% нийслэлд, 13.1% орон нутагт бүртгэгдсэн байна.³ Үүнийг хүснэгтэд оруулан харуулбал:

Хүснэгт №1

Явган зорчигч зам тээврийн осолд өртсөн сүүлийн 5 жилийн судалгаа							
№	Он	Улсын хэмжээнд		Нас барсан		Гэмтсэн	
		Нас барсан	Гэмтсэн	Нийслэл	Орон нутаг	Нийслэл	Орон нутаг
1	2017 он	143	2359	72	71	2141	218
2	2018 он	132	2501	82	50	2312	189
3	2019 он	140	1949	88	52	1616	333
4	2020 он	165	1230	82	83	988	242
5	2021 он	129	1095	72	57	875	220

Дээрхи хүснэгтээс харвал замын хөдөлгөөнд оролцогч⁴ийн нэг болох явган зорчигч нь зам тээврийн осолд өртөж нас барсан, гэмтсэн иргэдийн дийлэнхи хэсгийг эзэлж байгаа бөгөөд харьяалалын хувьд нийслэлд хамаарч байгаа нь анхаарвал зохих нэг чухал асуудал болж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай шинэ хууль 2015 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэхүү хуульд анх удаа явган зорчигчид ногдох хариуцлагын механизмыг оруулж өгсөн билээ. Өөрөөр хэлбэл, өмнө нь жолооч явган зорчигчид зам тавьж өгөх үүрэгтэй байсан бол шинэ хуульд замын хөдөлгөөнд хууль зорчиж оролцсон явган зорчигчид хариуцлага хүлээлгэх талаар зааж өгсөн юм.

Тээврийн прокурорын газар 2016 онд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг 916 хэрэг бүртгэж, шалгасны 147 нь явган зорчигчийн буруугаас болсоныг тогтоосон нь осол аваарт явган зорчигч багагүй үүрэгтэй оролцдогийг баталж, хуулийн зөв зүйтэйг баталсан гэж болно. Мөн зам тээврийн 3305 ослын 705 нь явган зорчигч буруугаас үүдэн гарсан, зорчигчийн буруугаас болсон 705 ослын 414 нь согтуугаар замын хөдөлгөөнд оролцсоноос, 291 нь гарцгүй хэсгээр зам хөндлөн гарснаас үүдэлтэй гэх тоо баримтууд дүрэмд явган зорчигчийн хариуцлагыг өндөржүүлэх заалт оруулах залшгүй шаардлагатай байсныг харуулдаг.

³ Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын тайлан мэдээнээс хэсэгчилэн авав.

⁴ "замын хөдөлгөөнд оролцогч" гэж замаар явж байгаа жолооч, тээврийн хэрэгслээр зорчигч, явган зорчигчийг ойлгоно. /Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3.1.7/

Энэ бол жолоочид ч, явган зорчигчид ч хүндрэлгүй, аль ч талаас нь бодсон зөв шийдвэр юм. Гэхдээ гарцгүй газраар гарснаас үүдсэн осол гарц хангалгүй байгааг бас харуулж байгаа гэдгийг бодолцох л ёстой. Төвөөс алслагдсан зам дээр автомашинууд харьцангуй хурдтай зорчдог гэтэл чухам энэ хэсэгт явган хүний гарц хол зайтай, хангалтгүй байдаг нь тулгамдсан асуудал болж байна.

Угтаа энэ бол нэг талаас төр, нутгийн захиргааны байгууллагын хүрээнд шийдчих боломжтой асуудал бөгөөд гарцыг нь тодорхой зай тутамд тавиад өгчихөд болно. Харамсалтай нь, энэ асуудал улсын хэмжээнд байтугай нийслэл хотод ч учир дутагдалтай байгаад төр засгаас анхаарах шаардлага тулгарч байна.

Замын хөдөлгөөнд оролцогч явган зорчигчийн эрх зүйн байдал нь дараах хууль, эрх зүйн актуудаар тодорхойлогдж байна. Тухайлбал:

- **Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль:**

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 12 дугаар зүйл /Замын хөдөлгөөнд оролцогчийн эрх, үүрэг/-ийн 12.1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай үндэсний хууль тогтоомж болон Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлж, замын хөдөлгөөнд оролцогчийн замын хөдөлгөөнд аюулгүй оролцох эрхийг хуулиар хамгаална.

Замын хөдөлгөөнд оролцогч явган зорчигч нь уг хуулийн 12.2-д зааснаар дараах эрх эдэлнэ. Үүнд;

- 1.Замын хөдөлгөөний дүрмийг баримтлан саадгүй зорчих;
- 2.замын хөдөлгөөнд аюулгүй оролцох нөхцөлөө хангуулахаар төрийн холбогдох байгууллага, албан тушаалтанд шаардлага тавих;
- 3.зам тээврийн ослын үед эмнэлгийн болон авран хамгаалах бусад яаралтай тусламжийг холбогдох төрийн байгууллага, хариуцсан этгээдээс үнэ төлбөргүй авах;
- 4.зам тээврийн ослын улмаас учирсан хохирлоо хуульд заасны дагуу нөхөн төлүүлэх.

Замын хөдөлгөөнд оролцогч явган зорчигч нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг биелүүлэх үүрэгтэй.

Мөн энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг”⁵-ээр явган зорчигчийн зарим эрх зүйн байдал тодорхойлогдож байна. Гэхдээ замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг гэсэн нэршлийн дор зарим эрх зүйн байдал тодорхойлогдож байна.

Уг хуулийн 13.1-д замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар иргэн, хуулийн этгээдийн эдлэх эрхийн талаар тусгажээ. Үүнд:

- холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас замын хөдөлгөөнд хязгаарлалт буюу хориглолт тогтоосон шалтгаан, нөхцөл, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн аливаа техник хэрэгсэл, ажил, үйлчилгээний талаар мэдээлэл авах;
- замын эвдрэл, гэмтлийг засах, бохирдол, цас мөс цэвэрлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардах.⁶

Харин хуулийн 13.2-д замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар иргэн, хуулийн этгээдийн хүлээх үүргийг тусгажээ. Тухайлбал:

- Замын хөдөлгөөний дүрмийг сахин биелүүлэх;
- зам тээврийн осолд өртсөн хүнд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх;
- замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй буюу ядарсан үедээ явганаар болон тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцохгүй байх;

⁵ Төрийн мэдээлэл. 2015. №28. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль

⁶ Хууль тогтоомжийн эмхэтгэл /Тээврийн цагдаагийн алба/. УБ.2019. 158-159 дэх тал

- зам дээр болон түүний ойр орчимд ажил, үйлчилгээ хийхдээ замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;
- замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаар холбогдох байгууллагад шуурхай мэдээлэх;
- иргэн, хуулийн этгээд оршин байгаа газартаа хамаарах замын бохирдол, цас мөсийг цэвэрлэх;
- эцэг эх, асран хамгаалагч, бүх шатны боловсролын байгууллагын холбогдох албан тушаалтан 10 хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх;
- замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар эрх бүхий этгээдээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх⁷ зэрэг үүргийг хүлээж байна. Эдгээр нь замын хөдөлгөөнд оролцогч явган зорчигчийн эрх зүйн байдалд хамаарч байна.

• **Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм⁸**

Монгол Улсын замын хөдөлгөөнд оролцогч явган зорчигчтой холбоотой дараах хэдэн нэр томъёоны тодорхойлолт энэ дүрэмд тусгагдсан байна. Тухайлбал:

- 1.2.52. “явган зорчигч” гэж Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3.1.11-д заасныг;
- 1.2.53. “явган хүний гарц” гэж явган зорчигч зам хөндлөн гарахад зориулсан, 5.19.а, 5.19.б тэмдэг ба 1.13.а, 1.13.б тэмдэглэлтэй, зорчих хэсгийн хөндлөн зурвасыг. Тэмдэглэлгүй гарцын өргөнийг 5.19.а ба 5.19.б тэмдгүүдийн хоорондох зайгаар тодорхойлно;
- 1.2.54. “явган хүний гарам” гэж зорчих хэсэгтэй нэг түвшинд огтлолцоогүй, 5.20.а–5.20.г тэмдэг бүхий, явган зорчигч зам хөндлөн гарахад зориулсан гарцыг;
- 1.2.55. “явган хүний зам” гэж явган зорчигчийн хөдөлгөөнд зориулсан замын хэсгийг. Явган хүний зам нь зорчих хэсэг, унадаг дугуйн замаас хайс, хашлага, хөвөөгөөр тусгаарлагдсан, эсхүл унадаг дугуйн замаас тэмдэглэлээр зааглагдсан байна.
- 1.3. Замын хөдөлгөөнд оролцогч нь аюул, хохирол учруулахгүй, хөдөлгөөнд осолтой байдал бий болгохгүйгээр зорчино.⁹

Замын хөдөлгөөний дүрмийн Тав дугаар хэсэгт “Явган зорчигчийн үүрэг”-ийг тусгайлан зааж өгчээ.

5.1. Явган зорчигч нь явган хүний замаар, тийм зам байхгүй бол зорчих хэсгийн хажуугийн хөвөөгөөр явна. Явган хүний зам, хөвөө байхгүй буюу түүгээр явах боломжгүй тохиолдолд явган зорчигч нь унадаг дугуйн зам, эсхүл зорчих хэсгийн захаар (тусгаарлах зурвастай замд зорчих хэсгийн гадна талын захаар) цуварч явна. Тэрэг түрсэн, чарга чирсэн, овор ихтэй ачаа барьсан буюу жагсаалаар яваа, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний тэргэнцэртэй хүмүүс явган хүний зам, хөвөөгөөр явахад бусад явган зорчигчдод саад болохоор байвал зорчих хэсгийн захаар явж болно. Явган зорчигч зорчих хэсгийн захаар явахдаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөний чигийн эсрэг, харин хөгжлийн бэрхшээлтэй хүний тэргэнцэртэй буюу мотоцикл, мопед, унадаг дугуй хөтөлж яваа хүн хөдөлгөөний чигийн дагуу явна.¹⁰

⁷ Төрийн мэдээлэл. 2015. №28. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль

⁸ <https://news.cardoctor.mn/read/1088>

⁹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208663&showType=1>. Засгийн газрын 2018 оны 239 дүгээр тогтоолоор батлагдсан.

¹⁰ Тайлбар: Нэг чигийн хөдөлгөөнтэй замын зорчих хэсгийн захаар явах тохиолдолд дээрх заалтыг мөрдөхгүй байж болно.

5.2. Харанхуй үед гэрэлтүүлэггүй замд болон үзэгдэлт хангалтгүй нөхцөлд зорчих хэсгийн зах буюу хөвөөгөөр явах тохиолдолд явган зорчигч нь жолоочид харагдах нөхцөлөө сайжруулах үүднээс аль болох тод гэгээлэг өнгийн, боломжтой бол гэрэл ойлгох шинж чанар бүхий хувцас хэрэглэл, эд зүйлстэй явбал зохино. Мотоцикл, мопед, унадаг дугуй түрж яваа хүн тээврийн хэрэгслийнхээ гэрэлтүүлэх хэрэгсэл, гэрэл ойлгуурыг халхлахгүй явна.

5.3. Жагсаалаар яваа хүмүүс зорчих хэсгээр явах тохиолдолд дөрвөөс илүүгүйгээр зэрэгцэж хөдөлгөөний чигийн дагуу баруун гар талаар явна. Жагсаалын зүүн гар талын захын урд болон ард, өдрийн цагт улаан дарцаг, харанхуй үед болон үзэгдэлт хангалтгүй нөхцөлд урд нь цагаан, ард нь улаан гэрэл (эсхүл гэрэл ойлгуур) барьсан хүн харгалзаж явна.

5.4. Хүүхдийн жагсаалыг зөвхөн явган хүний замаар, явган хүний зам байхгүй бол зорчих хэсгийн хажуугийн хөвөөгөөр хоёроос илүүгүйгээр зэрэгцүүлж зөвхөн өдрийн цагаар явуулахыг зөвшөөрөх бөгөөд урд болон ард нь (хүүхдийн тоо гучаас олон бол жагсаалын мөн дунд хэсэгт) насанд хүрсэн хүн хамгаалж явна.

5.5. Явган зорчигч нь 10 хүртэлх насны хүүхдийг замын хөдөлгөөнд харгалзаж явахдаа (энэ дүрмийн 5.4-т заасны дагуу жагсаалаар авч яваагаас бусад тохиолдолд) өөрөөсөө салгахгүй (хөтлөх, тэврэх, үүрэх, хүүхдийн тэргэнд түрэх гэх мэт) авч явна.

5.6. Явган зорчигч нь явган хүний гарц буюу гармаар зам хөндлөн гарна. Хэрэв үзэгдэх хүрээнд явган хүний гарц, гарам байхгүй бол замын дагуу хоёр тийш сайн харагдах, хайс, хашилтгүй хэсгээр, ойртон ирж яваа тээврийн хэрэгслийг өнгөрүүлэн эгц хөндлөн гарна.¹¹

5.7. Хөдөлгөөний зохицуулгатай хэсгээр явган зорчигч зам хөндлөн гарахдаа явган хүнд зориулсан гэрлэн дохио буюу зохицуулагчийн зөвшөөрсөн дохиогоор зорчих хэсэг рүү орох бөгөөд зорчих хэсгийг хөндлөн гарч амжаагүй байхад дохио өөрчлөгдвөл энэ дүрмийн 8.21-д заасныг баримтална. Явган зорчигчид зориулсан гэрлэн дохио байхгүй (эсхүл ажиллахгүй) бол явах чигийн өөдөөс хандан байрласан, зэрэгцээ хөдөлгөөний тээврийн хэрэгсэлд зориулсан гэрлэн дохиог удирдлага болгоно.

5.8. Замын дагуу үзэгдэлт халхалсан саад, зогсож байгаа тээврийн хэрэгслийн дэргэдүүр зам хөндлөн гарахдаа тээврийн хэрэгсэл ойртон ирж байгаа эсэхийг магадлан мэдсэн байвал зохино.

5.9. Явган зорчигч замын аль ч хэсэгт тусгай дуут болон гэрлэн дохио ажиллуулсан (шар өнгийн дохио ажиллуулж яваагаас бусад) автомашин, мотоцикл болон тэдгээрээр хамгаалуулж яваа тээврийн хэрэгслийг урьдчилан өнгөрүүлнэ. Ийм тээврийн хэрэгсэл ойртон ирж яваа үед зорчих хэсэг дээр явж байсан явган зорчигч аль болох яаралтай зорчих хэсгийг чөлөөлнө.

5.10. Харааны бэрхшээлтэй хүн зорчих хэсгээр хөндлөн гарахдаа цагаан таяг барьсан байвал зохих бөгөөд хэрэв зорчих баримжаа алдаж, явган хүний гарцын байршлыг тогтоож чадахгүй болсон буюу гэрлэн дохионы заалтыг мэдэх боломжгүй бол бусдын туслалцааг авах, ийм бололцоогүй тохиолдолд таягаар сайтар дохио өгч анхаарал болгоомжтой зам хөндлөн гарна.¹²

5.11. Чиглэлийн тээврийн хэрэгсэл, таксигаар үйлчлүүлэх хүмүүс болон замын дагуух тээврийн хэрэгслээр зорчих хүмүүс зориулалтын хүлээлгийн талбай дээр, ийм талбай байхгүй бол зорчих хэсгийн хашлаганы гадна талд (явган хүний зам дээр буюу хөвөөний гадна захад), хайс, хашилтгүй хэсэгт хүлээх бөгөөд тээврийн хэрэгсэл ирж бүрэн

¹¹ Хууль тогтоомжийн эмхэтгэл /Тээврийн цагдаагийн алба/. УБ.2019. 158-159 дэх тал

¹² Тайлбар: Цагаан таяг нь харанхуй үед гэрэл ойлгодог буюу гэрэлтдэг гадаргуутай байвал зохино.

гүйцэд зогссон үед зорчих хэсэг рүү орохыг зөвшөөрнө. Тээврийн хэрэгслээс буусны дараа зорчих хэсгийг нэн даруй чөлөөлнө.¹³

Мөн уг дүрмийн 5.12-д явган зорчигчид хориглосон зүйлийг зааж өгсөн байна. Тухайлбал:

а/ үзэгдэх хүрээнд явган хүний гарцтай замын гарцгүй хэсгээр, эсхүл явган хүний гарамтай замын гарамгүй хэсгээр зам хөндлөн гарах;

б/ аюулгүй байдлыг хангахаас бусад шалтгаанаар зорчих хэсэг дээр зогсох, саатах, зам хөндлөн гарч байхдаа алгуурлах, эргэж буцах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд санаатайгаар саад хийх;

в/ зорчих хэсгээр явж байхдаа утсаар ярих, гар утас болон түүнтэй ижил төстэй тоглоом, хэрэгсэл оролдож ширтэх, зохицуулагчийн шүглийн чимээ, бусдын дуут дохио, анхааруулгыг сонсох боломжийг хязгаарласан чихэвч зүүх, ном, сонин зэрэг зүйл унших;

г/ зорчих хэсэг дээр дугуйт тэшүүр, дугуйт хавтан болон түүнтэй ижил төстэй, биеийн тамир, спорт, тоглоомын зориулалттай хэрэгслээр явах;

д/ ойртон ирж яваа тээврийн хэрэгслийн урдуур гэнэт гүйх.¹⁴

Түүнчлэн уг дүрэмд явган зорчигчийн замын хөдөлгөөнд оролцоход хамаарах замын хөдөлгөөн зохицуулах дохиотой холбоотой зохицуулалтууд байна. Тухайлбал:

- 8.6. Явган зорчигчийн хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохио нь босоо байрлалтай байх бөгөөд дээд талдаа улаан өнгөөр гэрэлтдэг зогсож буй хүний дүрс, доод талдаа ногоон өнгөөр гэрэлтдэг алхаж буй хүний дүрс бүхий дохиотой байна. Мөн харааны бэрхшээлтэй хүмүүст явган хүний гарцын байршлыг мэдэгдэх буюу тухайн гэрлэн дохионы ажиллагааны горимыг мэдээлэхэд зориулсан нэмэгдэл дуут дохиотой байж болно.

- 8.14. Зохицуулагчийн хөдөлгөөн зохицуулах дохио нь дараахь утгатай байна:

- а/ баруун гараа дээш өргөсөн байвал энэ дүрмийн 8.19-т зааснаас бусад тохиолдолд тээврийн хэрэгсэл замын тухайн хэсэг рүү явган зорчигч зорчих хэсэг рүү нэвтрэн орохыг хориглоно;

- б/ баруун гараа цээжиндээ авсан буюу гараа алдалсан байвал зохицуулагчийн зүүн болон баруун гар талаас яваа тээврийн хэрэгсэл чигээрээ буюу баруун гар тийш нэвтрэх, явган зорчигч зам хөндлөн гарахыг зөвшөөрөх бөгөөд зохицуулагчийн ар, өвөр талаас яваа тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөнийг хориглоно;

- в/ баруун гараа урагш сунгасан байвал зохицуулагчийн зүүн гар талаас яваа тээврийн хэрэгсэл бүх чигт, өвөр талаас яваа тээврийн хэрэгсэл зөвхөн баруун гар тийш эргэхийг зөвшөөрөх бөгөөд бусад талаас (баруун гар буюу ар талаас) яваа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглоно. Явган зорчигч зохицуулагчийн зөвхөн ар талаар зам хөндлөн гарахыг зөвшөөрнө.

- 8.15. Зохицуулагч нь жолооч, явган зорчигчдод хөдөлгөөний чиг өөрчлөх, байр эзлэх, хурд хасах буюу нэмэх, тойрон гарах, зогсох зэрэг үйлдэл хийхийг заасан ойлгогдохуйц дохио өгч болно.

- 8.18. Гэрэл буюу зохицуулагчийн хориглосон дохиогоор жолооч «Зогс-шугам» (1.11 тэмдэглэл буюу 5.32 тэмдэг)-ийн өмнө зогсох бөгөөд хэрэв тийм тэмдэг, тэмдэглэл байхгүй бол тухайн уулзвар, явган хүний гарцын өмнө, бусад газарт тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөнд саад болохгүйгээр гэрлэн дохио, зохицуулагчийн наана, эсхүл энэ дүрмийн 17.5-д заасны дагуу төмөр замын гармын өмнө зогсоно.

¹³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208663&showType=1>. Засгийн газрын 2018 оны 239 дүгээр тогтоолоор батлагдсан.

¹⁴ Хууль тогтоомжийн эмхэтгэл /Тээврийн цагдаагийн алба/. УБ.2019. 158-159 дэх тал

- 8.21. Зөвшөөрсөн дохиогоор явган хүний гарц руу орсон явган зорчигч дохио өөрчлөгдвөл аль болох яаралтай зорчих хэсгийг нэвтрэн гарах бөгөөд боломжгүй бол тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эсрэг урсгалын зааг дээр зогсож аюулгүй байдал хангагдсан үед хөдөлгөөнөө үргэлжлүүлэх буюу дараагийн зөвшөөрөх дохиог хүлээж нэвтрэнэ.

Замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч явган зорчигчтой тааралдах тохиолдолд дараах заалтыг баримтлана. Тухайлбал:

- 13.5. Жолооч явган хүний гарцын өмнө гүйцэх үйлдэл хийхдээ энэ дүрмийн 16.3-т заасныг баримтлах бөгөөд мөн хороолол, сургууль орчмын бүс дотор болон 1.19 тэмдгээр анхааруулсан замын хэсэгт гүйцэгдэж байгаа тээврийн хэрэгслийн урдуур явган зорчигч явж байгаа эсэхийг анхаарч мэдсэн байвал зохино.¹⁵

- 4.4. Энэ дүрмийн 14.3-т зааснаас бусад газарт болон мөн 7.4.ж нэмэлт тэмдгээр заасан зориулалтын зогсоол байхгүй газарт унадаг дугуй, мопедыг явган зорчигчийн хөдөлгөөнд саад болгохгүйгээр явган хүний зам дээр зогсоохыг зөвшөөрнө.

Явган зорчигч уулзвар нэвтрэхтэй холбоотой дараах зохицуулалт уг дүрэмд байна. Тухайлбал:

- 15.1. Жолооч уулзвараар баруун, зүүн гар тийш эргэхдээ тухайн хөндлөн замын зорчих хэсгийг явган хүний гарцаар хөндлөн гарч яваа явган зорчигч, мөн унадаг дугуйн зам буюу эгнээний огтлолцлоор хөндлөн гарч яваа унадаг дугуй, мопедод зам тавьж өгнө.

- 15.7. Зөвшөөрсөн гэрэл дохио асах үед жолооч нь уулзвар нэвтрэх үйлдлээ дуусгаж байгаа тээврийн хэрэгсэл, зорчих хэсгийг хөндлөн гарч амжаагүй яваа явган зорчигчид зам тавьж өгнө.¹⁶

Явган зорчигч явган хүний гарцаар нэвтрэхдээ уг дүрэмд заасан дараах зохицуулалтыг мөрдлөгө болгоно. Үүнд:

- 16.1. Явган хүний зохицуулдаггүй гарц руу ойртон ирсэн жолооч хурдаа хасаж, уг гарцаар гарч байгаа болон гарахаар завдаж байгаа явган зорчигчид зогсож зам тавьж өгнө.¹⁷

- 16.2. Зөвшөөрсөн гэрэл дохио асах үед жолооч явган хүний гарцыг нэвтрэхдээ зорчих хэсгийг хөндлөн гарч амжаагүй яваа явган зорчигчид зам тавьж өгнө.

Явган зорчигч хорооллын доторх хөдөлгөөнд оролцохдоо дараах зохицуулалтыг мөрдлөгө болгоно. Тухайлбал, уг дүрмийн 19.1. “Хорооллын дотор явган зорчигч нь явган хүний замаас гадна зорчих хэсгээр явж болно. Хорооллын дотор явган зорчигч давуу эрхтэй зорчих бөгөөд ингэхдээ тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд санаатайгаар саад хийхийг хориглоно” гэсэн заалтыг мөрдлөгө болгоно.

Тууш замын хөдөлгөөнд явган зорчигч оролцохдоо Замын хөдөлгөөний дүрмийн 20.1.а “явган зорчигч, ердийн хөсөг, унадаг дугуй, мопед, трактор болон өөрөө явдаг машин механизм, мөн техникийн дээд хурд нь цагт 40 км-ээс илүүгүй тээврийн хэрэгслийн хөдөлгөөн” гэсэн хориглосон заалтыг мөрдлөнө.

Зам дээр засварын ажил, үйлчилгээ эрхэлж буй иргэн, хуулийн этгээд нь Замын хөдөлгөөний дүрмийн 27.4.г-д заасан “засварын ажил, үйлчилгээг дуусгасны дараа

¹⁵ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208663&showType=1>. Засгийн газрын 2018 оны 239 дүгээр тогтоолоор батлагдсан.

¹⁶ Хууль тогтоомжийн эмхэтгэл /Тээврийн цагдаагийн алба/. УБ.2019. 178-179 дэх тал

¹⁷ Тайлбар: Явган хүний зохицуулдаг ба зохицуулдаггүй гарцыг энэ дүрмийн 15.3-т заасан зохицуулдаг ба зохицуулдаггүй уулзварын тодорхойлолттой адилтгаж ойлгоно.

тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн аюулгүй, хэвийн зорчих нөхцөлийг бүрдүүлэх”¹⁸ гэсэн үүргийг хүлээнэ.

Дээрхи хууль, эрх зүйн актад явган зорчигчийн замын хөдөлгөөнд оролцохтой холбоотой бүхий л харилцаа зохицуулагдаж чадсан гэж үзэж байна. Гэхдээ явган зорчигчийн замын хөдөлгөөнд оролцохтой холбоотой зохицуулалтыг иргэд тэр бүр мэдэхгүй, явган зорчигчдын замын хөдөлгөөнд оролцохтой холбоотой эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхтэй холбоотой ажил, арга хэмжээ учир дутагдалтай байгаатай салшгүй холбоотой байна.

Шинэ дүрэмд орсон өөрчлөлтүүдээс авч үзвэл явган зорчигч нь зорчих хэсгээр явж байхдаа:

- Утсаар ярих,
- Гар утас болон түүнтэй ижил төстэй тоглоом, хэрэгсэл оролдож ширтэх,
- Зохицуулагчийн шүглийн чимээ, бусдын дуут дохио, анхааруулгыг сонсох боломжийг хязгаарласан чихэвч зүүх,
- Ном, сонин гэх мэт зүйл унших”,
- Зорчих хэсэг дээр дугуйт тэшүүр, дугуйт хавтан болон түүнтэй ижил төстэй, биеийн тамир, спорт, тоглоомын зориулалттай хэрэгслээр явахыг хориглосон байна.
- Хороолол дотор гүйцэж түрүүлэх үйлдэл хийхийг жолоочид хориглолоо.
- Жолооч явган хүний гарцаар гарч байгаагаас гадна мөн гарахаар завдаж байгаа явган зорчигчид зогсож зам тавьж өгөх үүрэг хүлээнэ.
- Долоон нас хүрээгүй хүүхдийг насанд хүрсэн харгалзах хүнгүйгээр тээврийн хэрэгсэлд үлдээхийг хоригложээ.
- 10 хүртэлх насны хүүхдийг тээвэрлэхдээ биеийн жин, өсөлтөд нь тохирсон зориулалтын нэмэгдэл суудал буюу хамгаалах хэрэгсэл ашиглана.
- Харааны бэрхшээлтэй хүний цагаан таяг нь харанхуй үед гэрэл ойлгодог буюу гэрэлтдэг гадаргуутай байх шаардлагыг тусгажээ.
- Өөрийн үйлдлийг хянах чадваргүй хөгжлийн бэрхшээлтэй /сэтгэцийн өвчтэй/ хүнийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд явганаар оролцуулахгүй..
- Автобусаар зорчигчийн аюулгүй байдлыг хамгаалах үүднээс хаалгыг жолоочийн суудлаас удирддаг бол гүйцэд зогсоогүй байхдаа хаалга нээхийг хориглолоо.
- Зорчигчийг суурин газрын доторх чиглэлийн тээврийн хэрэгслээр тээвэрлэхээс бусад тохиолдолд зогсоогоор нь тээвэрлэхийг хориглосон байна.
- Жолоочийн өвөр дээр, эсвэл суудлын ба ачааны автомашины жолоочийн бүхээгт зорчигчийн өвөр дээр хүн тээвэрлэх, өөрийн үйлдлийг хянах чадваргүй (согтуурсан, мансуурсан гэх мэт) хүнийг урд суудалд, эсвэл жолоочоос өөр харгалзаж хамгаалах хүнгүйгээр тээвэрлэхийг хоригложээ.
- Замын зэргэлдээх нутаг дэвсгэр, ялангуяа явган хүний хөдөлгөөн ихтэй үзвэр, худалдаа үйлчилгээний талбайд цагт 20 км-ээс илүү хурдтай явахыг хориглов.
- Суудлын таксинд нэгдүгээр эгнээгээр зорчихыг зөвшөөрчээ.
- Зарим уулзварт баруун гар тийш эргэх тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөнийг байнгын нээлттэйгээр зохион байгуулах эрх зүйн зохицуулалттай болжээ.
- Уулзварыг бүрэн гүйцэд нэвтрэн гарах боломжийг хязгаарласан түгжрэл, саатал бий болсон үед жолооч уулзвар руу орохыг хоригложээ.

Гэтэл өнөөдөр явган зорчигчид гарцгүй газраар зам хөндлөн гарах явдал арилсангүй, зам тээврийн осол, зөрчилд өртсөөр байгаа нь тулгамдсан асуудал болоод байна. Учир нь явган хүний гарц хоорондын зай зарим алслагдсан газруудад хэтэрхий хол байна. Ийм

¹⁸ Хууль тогтоомжийн эмхэтгэл /Тээврийн цагдаагийн алба/. УБ.2019. 193 дахь тал

газар мэдээж иргэд гарц хайж гүйхгүй ч “Цагдаа байхгүй бол хамаагүй” гэсэн дүрэм өөрсдөө хэрэгжүүлээд байна. Замын хөдөлгөөний дүрэм болон бусад холбогдох баримт бичгүүдэд явган хүний гарцыг хэдэн метр тутамд байрлуулах ёстой талаар эрх зүйн зохицуулалт өнөөгийн хууль тогтоомжид тусгагдаагүй байна.

Замын дохио тэмдгийн тухай конвенци¹⁹д “Явган хүний гарцын өргөний хэмжээ нь хөдөлгөөний хурд 60 км/ц-аас илүүгүй зам дээр 2.5 метр түүнээс илүү буюу хурд хязгаарлагдаагүй зам дээр дөрвөн метр хүртэл хэмжээтэй байх” гэсэн заалт байхаас тууш замд тэдэн метр тутамд явган хүний гарц байна гэсэн заалт байхгүй байна.

Энэ нь явган зорчигч хуульд заасан үүргээ биелүүлэхийн тулд ихээхэн тэсвэр тэвчээр гаргах хэрэгтэй болж байна. Орон нутгийн замд явган хүний гарцын тэмдэглэгээ байхгүй бөгөөд тэр зам дээр осол гарвал хуулиараа “Гарцаар гараагүй” гээд явган зорчигчид хариуцлага тооцох ёстой²⁰ болж байна.

Дүгнэлт. Замын хөдөлгөөнд оролцогч явган зорчигчийн эрх зүйн байдал нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомжид буюу Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай хууль болон Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд бүрэн тусгагдсан байна. Гэвч явган зорчигчид зам тээврийн осол, зөрчилд өртөж нас барах, бэртэж гэмтэх явдал буурахгүй байгаа нь нэг талаас явган зорчигчдын эрх зүйн мэдлэг дутмаг байгаа, нөгөө талаас явган зорчигчдын замын хөдөлгөөнд оролцохтой холбоотой хууль эрх зүйн мэдлэг сургалт, сурталчилгаа хангалтгүй байгаатай холбоотой байна.

Түүнчлэн нийслэл хотын түгжрэлтэй холбоотойгоор иргэдийн бухимдал, яарч сандарсан, хурдан явахыг хүссэн, эцэг эхийн хараа хяналтгүйгээр замын хөдөлгөөнд оролцох явдал түгээмэл байгаатай холбон үзэж болохоор байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Замын хөдөлгөөнд оролцогч явган зорчигчийн эрх, үүргийг тусгасан цуврал сургалт, сурталчилгааг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээгээр тогтмол явуулж, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж явуулах;
2. Явган зорчигч хамгийн их осолд орж байгаа хар цэгүүдийн судалгааг гаргаж, гүүр болон нүхэн гарцуудын тоог нэмэгдүүлэх ажлыг нийслэлийн Засаг даргад танилцуулан шийдвэрлүүлэх;
3. Нийслэл хотын төв зам дагуух явган хүний гарцын тоог нэмж, хяналтыг чангатгах;
4. Явган зорчигч хамгийн осолд ороод байгаа гарц, хэсгүүд дээр ажиллах олон нийтийн цагдаагийн ажилтны орон тоог ИТХ-д танилцуулж шийдвэрлүүлэх зэрэг болно.

¹⁹ http://www.traffic-institute.mn/i_advertisement/i-01/i-01.html

²⁰ <http://eagle.mn/r/55422>